



Гарчиг	
Хүснэгтийн жагсаал.....	3
Зургийн жагсаалт	3
График.....	4
1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	5
1.1. Төслийн нэр, төрөл.....	5
1.2. Төслийн зорилго.....	5
1.3. Төсөл хэрэгжүүлэгч	5
1.4. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг.....	5
1.5. Төслийн байршил	5
1.6. Төсөл хэрэгжиж буй орчны тойм зураг	6
1.7.Төслийн хүчин чадал.....	6
1.8 Төслийн үндсэн тоног төхөөрөмж	7
2. ТӨСӨЛ ХЭРЭГГИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	8
2.1. Дэд бүтэц.....	8
2.2. Уул зүй	8
2.3. Ус зүй.....	9
2.4. Уур амьсгал, биологийн олон янз байдал	9
2.5. Хүн ам.....	10
2.6. Мал, аж ахуй	12
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	13
3.1. Агаар мандал.....	13
3.2. Ус	13
3.3. Ан амьтан, мал.....	13
3.4. Байгалийн нөөц, баялгийг зохистой ашиглана.....	15
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
5.1. Агаар орчны бохирдолт	17
5.2. Усны бохирдлоос сэргийлэх	18
5.3. Хөрсний бохирдол, элэгдэл, эвдрэл	19
5.4. Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй	23
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	28



7.	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	33
7.1	Мод тарих	33
7.2	Техникийн нөхөн сэргээлт	35
8.	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	37
9.	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	37
10.	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	37
11.	ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	37
12.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	42
13.	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	50
14.	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	51
15.	УРД ДЭЛЭНГИЙН ДЭНЖ УУРХАЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НИЙТ ЗАРДАЛ ..	52



Хүснэгтийн жагсаал

Хүснэгт 1. Талбайн солбилцол	6
Хүснэгт 2. Уулын ажлын үндсэн тоног төхөөрөмж	7
Хүснэгт 3. Заамар сумын малын тоо толгой 2022 оны байдлаар	12
Хүснэгт 4. Агаарын орчны бохирдолтонд хийгдсэн ажлууд.....	17
Хүснэгт 5. Усны бохирдолдтоос сэргийлэхэд хийгдсэн ажлууд	18
Хүснэгт 6. Хөрсний бохирдолтоос сэргийлэхэд хийгдсэн ажлууд.....	19
Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	24
Хүснэгт 8. 2023 оны техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	28
Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	32
Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	36
Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн хураангуй	38

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн талбай	6
Зураг 2. MV-000704 лицензийн дугаартай талбайн нөхөн сэргээлтийн талбай.....	14
Зураг 3. Уурхайн ажилчдын хотхон.....	15
Зураг 4. Засварын цех	16
Зураг 5. Техникийн нөхөн сэргээлт хийгдэж буй талбай.....	17
Зураг 6. Хаягдал тос масло цуглуулах, хадгалах талбай.....	20
Зураг 7. Уурхайн талбайн машинистийн хаягдал тос цуглуулах машин	20
Зураг 8.Шимт хөрс тээвэрлэх үйл явц	20
Зураг 9. Шимт хөрс хуулах үйл явц	20
Зураг 10. Засвар үйлчилгээний цементилсэн талбай.....	21
Зураг 11. Хаягдал тос тосох, тусгай талбайн хэсэг.....	21
Зураг 12. Ахуйн хог хаягдал зөөх, ачих машин	21
Зураг 13. Ахуйн хог хаягдлын хогийн сав.....	21
Зураг 14. Усалгааны машин зам талбай усалж буй байдал	22
Зураг 15. Хурд хязгаарлах замын тэмдэг, тэмдэглэгээ	22
Зураг 16. Шимт хөрс хуулж овоолсон байдал.....	29
Зураг 17. Дотоод овоолго хэлбэржүүлж нөхөн дүүргэлт хийж буй байдал.....	30
Зураг 18. Хөрсний овоолгийг тараан хэлбэржүүлсэн байдал.....	30
Зураг 19. Шимт хөрсний конусан овоолго тараасан байдал.....	31
Зураг 20. Мод суулгац тарьж буй байдал	34
Зураг 21. Мод суулгаж тарьсан байдал.....	34
Зураг 22. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Өгөөмөр овооны урд хэсэгт техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбай.....	35
Зураг 23. Хатуу хог хаягдал зөөвөрлөх машин	39
Зураг 24. Хатуу хог хаягдал цуглуулах талбай.....	39
Зураг 25. Хуванцар сав, шил лааз цуглуулах хогийн цэг.....	39



Зураг 26. Хуванцар сав, шил лааз цуглуулах хадгалах талбай.....	39
Зураг 27. Хөрс бордооны сав, баглаа боодлыг хадгалах агуулах.....	40
Зураг 28. Техникийн ашиглагдсан батарей, аккумулятор хадгалах агуулах	40

График

<i>График 1. Заамар сумын хүн амын тоо 2013-2022 байдал (Үндэсний статистик хороо)</i>	11
<i>График 2. Заамар сумын малчин өрхийн тоо 2013-2022 оны байдал (Үндэсний статистикийн хороо)</i>	11



1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр, төрөл

“Урд дэлэнгийн дэнж” уурхайн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

1.2. Төслийн зорилго

2023 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр батлагдсан алтыг олборлоход учрах сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээлтийн ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж унаган төрхөнд нь ойртуулах.

1.3. Төсөл хэрэгжүүлэгч

“Уулс Заамар” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 1411007090

Регистрийн дугаар: 2819996

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-016718

1.4. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг

Төв аймаг, Заамар сум, 3-р баг, Хайлааст, “Уулс Заамар” ХХК-ийн кэмп

Утас: 99096222, Захирал З.Батбаатар

1.5. Төслийн байршил

Урд дэлэнгийн дэнж талбай нь Төв аймгийн Заамар сумын нутагт, Туул голын зүүн эрэгт Улаанбаатар хотоос 240 орчим км-т, Булган аймгаас ЗУ 100 км-т, Эрдэнэт хотоос ЗУ 130 км-т, Заамар сумаас БХ 40 орчим км-т, Хайлааст багийн төв Өгөөмөр тосгоноос БУ 12 орчим км-т оршино.

Урд дэлэнгийн дэнж алтны шороон орд нь ашигт малтмалын ашиглалтын MV-016718 тоот тусгай зөвшөөрөлтэй 76.04 га талбайг хамарч М-48-137 тоот хавтгайд байрлана (Зураг 1).



Хүснэгт 1. Талбайн солбилцол

№	X	Y
1	104° 19' 25.93"	48° 11' 13.81"
2	104°18' 42.06"	48° 11' 13.81"
3	104°18' 41.70"	48° 11' 40.89"
4	104°19' 25.93"	48° 12' 40.89"

1.6. Төсөл хэрэгжиж буй орчны тойм зураг



Зураг 1. Төслийн талбай

1.7.Төслийн хүчин чадал

Ашиглалтын ажлыг 2023 онд Урд дэлэнгийн дэнж гүний хэсгийн блокуудад явуулсан ба дотоод овоолгоор нөхөн сэргээлтийн ажлыг олборлолтын явцад хамт гүйцэтгэж уг ордыг хаягдал багатайгаар орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэн ашиглаж байна. Улсын чанартай баяр ёслолын өдрүүдэд амарна. Харин техник тоног төхөөрөмжүүдэд үзлэг, үйлчилгээ, урсгал засвар хийх хугацааг сард 2 өдөр хийж байсан.



- Жилд ажиллах хоног 90 хоног
- Элс угаах ажлын хоног 85 хоног
- Амралт, баяр ёслолын өдрүүд 4 хоног
- Урсгал засвар хийх өдрүүд 10 хоног
- Ээлжийн тоо 2 ээлж
- Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 10-12 цаг

1.8 Төслийн үндсэн тоног төхөөрөмж

Урд дэлэнгийн дэнж алтны шороон ордод уулын ажил явуулахад дор дурьдсан техник хэрэгслийг ашигласан.

Хүснэгт 2. Уулын ажлын үндсэн тоног төхөөрөмж

Д/д	Тоног төхөөрөмж	Нийт
1	Hitachi Eхe 470, 870 Эхскаватор (Хөрс хуулалт, нөхөн сэргээлтэнд)	4
2	Hitachi Eхe 350 Эхскаватор (Элс олборлолт)	1
3	John deer 850J	1
4	Howo Автосамосвал	11
5	Hitachi Eхe 210, 330 Эхскаватор (Туслах ажил болон Угаах төхөөрөмж тэжээх)	3
6	Screen – 80 Угаах төхөөрөмж	1
7	John Deer Ачигч	1
8	Land Criuser 80 Суудлын машин	2
9	Toyota Dyna Ачааны машин	2
10	Isuzu Ачааны машин	1



2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Дэд бүтэц

Монгол орны физик газар зүйн мужлалаар Хангай Хэнтийн уулархаг мужийн Сэлэнгэ, Орхоны сав дахь бэсрэг уулсын район, Хэнтийн уулархаг мужийн баруун урьд хэсэгт Захцагийн нуруу, Заамарын нурууны төгсгөлд Өндөр улаан уул, Өлийн даваа /1224,1 м/, Бага өл /1061 м/, Цогт уул /1384 м/, Галтын уул болон Заамарын цагаан овоо /1560 м/ зэрэг уул зүйн систем зонхилдог ба гадаргуугийн хамгийн нам цэг нь Туул голын зүүн эрэг дээр байрлах бөгөөд харьцангуй өндөржилт нь 953-1035 м-ийн хооронд хэлбэлзэнэ.

Нийт нутаг нь өвс ургамлаар бүрэн бүрхэгдсэн, чулуулгийн гарш илэрц муу, харин уулын өмнөд хажуунууд чулуулгийн гарш илэрц сайтай, заримдаа бага хэмжээний нуранги, хад цохиотой байдаг.

Талбайн хэмжээнд усан сүлжээ нилээд сайн хөгжсөн ба хамгийн том гол нь Туул гол юм. Туул гол нь талбайн баруун талаар уртрагийн дагуу чиглэлтэйгээр өмнөдөөс хойш урсан өнгөрдөг. Голын гольдрол нь бага зэрэг тохойрон тахирлах, заримдаа салаалж урсах ба жижиг арлууд голын дунд цөөнгүй тохиолдоно. Усны өргөн нь 3-6 м, гүн нь 1.0 м-ээс хэтэрдэггүй.

2.2. Уул зүй

Урд дэлэнгийн дэнж талбай нь Монгол орны геоморфологийн Хангай хэнтийн уулст өндөрлөг мужлалтад багтдаг. Хотгор гүдгэрийн үндсэн хэв шинжээрээ бэсрэг уулын хэв шинжит гадаргуутай Хэнтийн уулархаг мужийн баруун урд хэсэгт Захцагийн нуруу, Заамарын нурууны төгсгөлд Өндөр улаан уул, Өлийн даваа (1224,1м), Бага Өл (1384м), Галтын уулын болон Заамарын Цагаан овоо (1560м) зэрэг уул зүй систем зонхилдог. Урд дэлэнгийн дэнжийн ордын талбай нь туул голын зүүн эрэг дээр байрлах ба үнэмлэхүй өндөр нь 953-1035м. Заамарын нуруу нь туул голын хөндий ба Заамарын хотгорын хооронд зүүн хойш сунаж тогтсон дунд уулархаг нутаг юм. Уул нуруудын үнэмлэхүй өндөр нь 1500-1700м, харьцангуй өндөр нь 150-200м, заримдаа 300м хүрэх ба хамгийн өндөр цэг нь далайн төвшнөөс дээш 1815.5м өргөгдсөн цагаан уул болно.



Мөн талбайн баруун хойд өнцөгт Захцагын нурууны салбар уулс, гурав толгой ба Галтын уулын салбар толгод байралдаг.

Судалгааны талбай нь Заамарын хотгорын баруун хойд хэсгийн бага хэмжээний талбайг эзэлдэг. Хотгорын үнэмлэхүй өндөр нь 1060-1250м-т өндөрлөг ба өмнө зүг рүү үл мэдэг налуу гадаргуутай байдаг. Энэ нутагт уулын орой усан хагалбаруудаар чулуулгийн илэрц сайтай, уулын хажуугаар дунд зэрэг, бэл хормойд нь янз бүрийн зузаантай сэвсгэр хурдсаар хучигдсан байдаг. Талбайн гадаргуудийн тогтоц нь Заамарын нуруу, Заамарын хотгор Туул голын хөндийн гэсэн төрлүүдээс бүрдэнэ.

2.3. Ус зүй

Гол мөрний сүлжээний нягтшилтын хувьд 1000 кв.км талбайд ноогдох гадаргуугийн урсац 50-100 км. Уг талбайн зүүн талын буланд Баруун галтын жалгын эхэнд бага хэмжээний ундаргатай булаг оршдог. Уг булгаас бороо хур ихтэй жил жижиг горхи урсаж булгийн эхнээс 500-700м орчимд Баруун Галтын жалга дагуу урсаад газар доогуур шургадаг. Талбайн бусад жалга (Галт, Галт2, Дунд галт) нь усны урсгалгүй хуурай байдаг.

Судалгааны талбайд хөгжсөн голын сүлжээний хамгийн том нь Туул гол юм. Туул гол нь талбайн баруун талаар бараг уртрагийн дагуу чиглэлтэйгээр өмнөдөөс хойш урсан өнгөрдөг.

Голийн гольдрол нь бага зэрэг тохойрон тахирлах, заримдаа салаалж урсах ба жижиг арлууд голын дунд цөөнгүй тэмдэглэгдэнэ. Голын гольдролын өргөн нь 30-100м, гүн 0,6-3м-т хэлбэлзэх бөгөөд голыг хөндийн хамгийн нам цэг нь талбайн хойд захад 953,1 м байдаг.

Голын урсгалын хурд 2,3-4,3 м/сек болно. Судалгааны талбайн хэмжээнд Туул голд цутгах ямар нэгэн урсгал устай гол, горхи байхгүй.

2.4. Уур амьсгал, биологийн олон янз байдал

Тус нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай болно. Хамгийн их хүйтрэлт өвлийн улиралд болох ба 1-р сарын дундаж хэм -26С хүрдэг. Харин зуны улиралд хамгийн их дулаарах ба 7-р сарын дундаж хэм нь +20 градус хүрнэ. Хүйтний улирал жил бүрийн 9-р сарын сүүлч 10-р сарын эхээр эхлэх ба 5-р сарын дунд үеэс дулаарна. Энэ



нутагт жилд дунджаар 363мм тунадас унах бөгөөд ихэнх 80-90% хэсэг нь 6 -8сард бороо хэлбэрээр унана. Өвлийн улиралд цасан бүрхүүлийн зузаан 150-250 мөрсний м-ээс хэтрэхгүй. Хөрсний улирлын хөлдөлт 2,0 м хүрдэг. Ихэвчилэн баруун хойноос салхилах ба салхины хурд жилд дунджаар 20м/сек болдог ба хаврын улиралд хүч нь нэмэгдэх 25м/сек хүрдэг.

Судалгааны талбайн хэмжээнд голын татмын, хуурай хөнддий, гуу, жалгын тал хээрийн болон модтой уулархаг нутгийн ландшафт хөгжсөн. Энд ойт хээрийн болон хээрийн ургамал зонхилох ба хөрсний бүслүүрийн хувьд тал хээрийн хүрэн хөрсний бүсэд хамаардаг. Талбайн хэмжээнд модлог ургамал байхгүй тачир өвслөг ургамалтай, талбайн орчимд өвслөг, бутлаг ургамал тохиолдох ба улиас мод ганц нэгээр ургана.


Амьтны аймгийн тухайд халиун буга (*Cervus elaphus*), зэрлэг гахай (*Sus scrofa*), бор гөрөөс (*Capreolus pygargus*), аргал хонь (*Ovis ammon*), саарал чоно (*Canis lupus*), мануул мий (*Otocolobus manul*), шар үнэг (*Vulpes vulpes*), халздай дорго (*Meles meles*) зэрэг хөхтөн амьтад гүйдлээр тохиолдоно. Төслийн талбай орчмын уулсын систем нь бүргэд, тас, шонхор зэрэг олон зүйл махчин шувуудын хувьд үүрлэхэд тохиромжтой орчинг үүсгэх бол голын хөндий, татмаар төрөл бүрийн ус, намгархаг газрын шувууд үүрлэж, өндөглөнө. Харин Туул голд цурхай, алгана, цулбуур зэрэг загас амьдардаг гэж тэмдэглэсэн байдаг.

2.5. Хүн ам

Заамар сумын нийт хүн амын тоо 2014-2018 онуудад тогтмол өсөж 5963 хүрсэн хэдий ч 2018 оноос хойш энэ тоо аажмаар буурах хандлагатай байна (График 1). 2022 оны тооллогоор 5802 иргэн бүртгэгдсэн бөгөөд энэ нь өмнөх жилтэй харьцуулахад 70 буюу 1.19%-иар буурсан үзүүлэлт юм. Харин 2022 оны хүн амын тоог баг тус бүрээр авч үзвэл Хайлааст баг хамгийн их (2482), удаагаар нь Төв (1519), Төмстэй (1064), болон Тосон (737) багууд тус тус орж байна (График 1).




График 1. Заамар сумын хүн амын тоо 2013-2022 байдал (Үндэсний статистик хороо)



Харин 2022 оны тооллогоор 1126 малчин өрх бүртгэгдсэн бөгөөд эдгээрийн 26% нь Тосон багт (292), 37% нь Төмстэй (415), 23% нь Хайлааст (257), 14% нь Төвийн багт (162) ноогдож байна (График 2). Заамар сумын нийт малчин өрхийн тоо өмнөх жилтэй харьцуулахад 99 буюу 8.79%-иар их байна.

График 2. Заамар сумын малчин өрхийн тоо 2013-2022 оны байдал (Үндэсний статистикийн хороо)





2.6. Мал, аж ахуй

2022 оны байдлаар Заамар сумын хэмжээнд нийт 292.481 толгой мал тоологдсоноос хонь 53.16%, ямаа 31.89%, адуу 7.69%, үхэр 7.18%, тэмээ 0.08%-ийг тус тус эзэлж байна. Тус сумын нийт малын тоог өмнөх онтой харьцуулахад 6.39%-иар, 2012 онтой харьцуулахад 1.5 дахин өссөн үзүүлэлттэй байна. Харин 2022 оны Заамар сумын нийт малын тоог баг тус бүрээр авч үзвэл Төмстэй багийн малын тоо 99.555 буюу 34%, Тосон баг 90.190 буюу 31%, Хайлааст баг 65.749 буюу 22%, Төв баг 36.987 буюу 13%-ийг тус тус эзэлж байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Заамар сумын малын тоо толгой 2022 оны байдлаар

Баг, хороо	Малын төрөл	2021 оны байдлаар малын тоо толгой (мянга)	2022 оны байдлаар малын тоо толгой (мянга)
Заамар сум	Бүгд	273.792	292.481
	Адуу	20.28	22.48
	Үхэр	19.065	20.994
	Тэмээ	0.211	0.247
	Хонь	144.269	155.477
	Ямаа	89.967	93.283
1-р баг, Тосон	Бүгд	82.43	90.19
	Адуу	7.097	7.544
	Үхэр	6.046	6.603
	Тэмээ	0.206	0.24
	Хонь	43.859	48.58
	Ямаа	25.222	27.223
2-р баг, Төмстэй	Бүгд	94.155	99.555
	Адуу	5.09	5.812
	Үхэр	4.794	5.153
	Тэмээ	0.005	0.007
	Хонь	55.268	57.966
	Ямаа	28.998	30.617
3-р баг, Хайлааст	Бүгд	63.565	65.749
	Адуу	5.118	5.805
	Үхэр	5.906	6.503
	Хонь	27.478	29.26
	Ямаа	25.063	24.181
	4-р баг, Төв	Бүгд	33.642
Адуу		2.975	3.319
Үхэр		2.319	2.735
Хонь		17.664	19.671
Ямаа		10.684	11.262



3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Агаар мандал

Хөрс хуулалтын явцад болон түүнийг түрж овоолон, алтны агуулга бүхий элсийг тээвэрлэж ашигласан, уурхайг буцаан тэгшлэх үед агаарт тоос шороо дэгдэх, хүнд машин механизмийг богино зайд олон эргэлттэйгээр ашигласнаас агаар дахь тоосжилт, утаа тортогийн хэмжээ CO₂, NO₂ ихсэж O₂-ийн хэмжээг багасгаж ажилласан

3.2. Ус

Технологийн процесст шаардагдах усыг ихэвчлэн гүний усаар хангахын зэрэгцээ борооны ус, хөрсний усыг усан санд хуримтлуулан ашиглана. Ийм нөхцөлд бохирдолын эх үүсвэр гүний худгийн ус болон усан санд хатуу шингэн хог хаягдал ил задгай хаях ба асгах, хөндий сав газрын хөрсийг нефьт бүтээгдэхүүнээр бохирдуулах зэрэг болно. Усны нөөцийн хомсдол нь хур тунадас бага жил хаврын урсац татрах үед гарна. Энэ жил Төв аймгийн хэмжээнд хур тунадасны хэмжээ 6-9-р саруудын нийлбэр дундажыг авч үзэхэд 69.7 мм байсан нь өмнө жилийн хур тунадасны хэмжээнээс 8 хувиар өссөн байна.

3.3. Ан амьтан, мал

Ан амьтан уурхайн дуу чимээнээс үргэж дайжих, мал амьтан ухсан нүх сувагт унаж бэртэх, үхэж хорогдох зэрэг сөрөг үр дагавар гарч болзошгүй байдаг тул бид байнгийн харуул хамгаалалт тавин ажилладаг.

Манай компаний MV-000704 дугаартай Туул голын баруун дэнж уурхайн нөхөн сэргээлт хийсэн талбайд 50-60 орчим тооны цагаан зээр нутаглаж байгаан ажиглагддаг (Зураг 2).



Зураг 2. MV-000704 лицензийн дугаартай талбайн нөхөн сэргээлтийн талбай

Ажиллагсад оршин суугчдын эрүүл мэнд

Орчны тоосжилт, тоног төхөөрөмжийн ажиллагааны үед гарах дуу чимээ нь оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, хөдөлмөрийн чадварыг бууруулж болзошгүй хүчин зүйл гэж авч үздэг мөн байгалийн давагдашгүй хүчин зүйл болох , аянга, цахилгаан, аадар бороо, үер, үерийн урсгал, гал түймэр зэрэг байгалийн гэнэтийн аюулд өртөж болзошгүй байдаг.



Зураг 3. Уурхайн ажилчдын хотхон

3.4. Байгалийн нөөц, баялгийг зохистой ашиглана

Алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах явцад хөрсний хими, физикийн чанар болон геологийн тогтоц геоморфологийн янз бүрийн өөрчлөлт гарч болно. Уурхайн орчин авто хөсөг, бульдозер өөрөөр явах механик хэрэгслийн замыг олон салаа гаргахгүй, хөрс, ургамал гэмтэх, хөрсний эвдрэл үүсэх, эрчимжих зэргээс урьдчилан сэргийлэхээс гадна шатах тослох материал хаягдаж алдагдсанаар хөрсөнд бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлж техникийн үзлэг оношилгоог тогтмол хийнэ. Техник тоног төхөөрөмжийг засварлахдаа тусгайлан засч бэлтгэсэн цементлэгдсэн талбайд гүйцэтгэдэг.



Зураг 4. Засварын цех

4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ ТҮҮНИЙ БИЕЛЭЛТ

Олборлолтын үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээлтийн ажлыг байгаль орчинд ээлтэй шинэлэг технологийг хэрэгжүүлж аль болох унаган төрхөнд нь ойртуулж гүйцэтгэх зорилт тавин ажилласан.

Урд дэлэнгийн дэнж алтны шороон ордын уурхайн үйл ажиллагаа 2023 оны 4 сарын 1-с эхэлсэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, орчны хяналт шинжилгээний ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн. 2023 онд олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, үүсэх эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч ашиглагдсан олборлолтын талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж хэрэгжүүлсэн (Зураг 5).



Зураг 5. Техникийн нөхөн сэргээлт хийгдэж буй талбай

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

5.1. Агаар орчны бохирдолт

Нөлөөлөл – Агаар (Хөрс хуулалт, элс олборлолт, тээвэрлэлт, элс, хөрсний овоолго)

Нөлөөлөлд өртөх объект – Уурхайн ойр орчимд байгаа хүн, амьтан, тоосны төвд орших уурхайн ажилчид, амьтан, ургамал

Хүснэгт 4. Агаарын орчны бохирдолтонд хийгдсэн ажлууд

Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Хөрс хуулалт, элс олборлолт, тээвэрлэлт, элс, хөрсний овоолго	
Техникийн хорт хий ялгарах Уурхайн үйл ажиллагаанд оролцож буй бүх техник хэрэгслүүдэд чанарын шаардлага хангасан түлш хэрэглүүлэх, машин техникийн засвар үйлчилгээг төлөвлөсөн хугацаанд тогтмол хийх	Тухайн онд уурхайд ажиллах техник, тоног төхөөрөмжүүдэд чанарын шаардлага хангасан түлш хэрэглэсэн. Уурхайн засварын хэсэг нь уурхай дээр ажиллаж буй бүхий л техник тоног төхөөрөмжийг хариуцан бүрэн бүтэн байдлыг байнга хянан засвар үйлчилгээний ажлыг тогтмол хийж байна
Орчны тоосжилт үүсэх Уурхайн талбайд хуурайшилт, тоосжилт ихтэй үед уурхайн гол зам, талбайг услах	Уурхайн олборлолтын ажлын үед зам, талбайн усалгааг шороо босгохгүй байхаар 18 м.куб багтаамжтай усалгааны зориулалтаар тоногдсон хово маркийн 1 ширхэг автомашинаар тогтмол усалгааны ажил хийж байна. Тоосжилтыг бууруулах үүднээс уурхайн бүсд бүх техник хэрэгслийг нэгдсэн нэг замаар явуулж хурдны хязгаарыг 20-30 км/цаг, ажилчдын тосгонд 5км/цагаар тогтоосон.



Уурхайн үйл ажиллагаанд оролцож буй бүх тээврийн хэрэгслийн агаарт гаргах хаягдалд ноогдуулах төлбөрийг төлөх

2023 онд нийтдээ 481,750 төгрөгийг “Уулс заамар” ХХК нь Төв аймгийн Заамар сумын татварын хэлтэст тушаасан

Уурхайд ашиглаж буй нийт техник, тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоог хийлгэх

Урд дэлэнгийн дэнж уурхайд ашиглагдаж байгаа бүх тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэгийг Төв аймгийн Авто тээврийн газраас очиж хийсэн. Үзлэгээр тээврийн хэрэгсэлүүд шаардлага хангасан техникийн дүгнэлт гарсан нь техник хэрэгслийн ялгаруулах утаа хүлцэх хэмжээнд байна.

5.2. Усны бохирдлоос сэргийлэх

Нөлөөлөл – Ус (Элсийг усаар угаах үйл ажиллагаа, баяжуулахад хэрэглэж буй угаалгын бохир усны сан, үерийн усны хамгаалалтын суваг шуудуу, далан, машин техникийн шатах тослох материал, унд ахуйн усны хэрэглээ)

Нөлөөлөлд өртөх объект – Газар доорх ус, малын бэлчээр, шимт хөрс бүхий газар, амьтан, мал, ургамал, ажиллагсад

Хүснэгт 5. Усны бохирдолдтоос сэргийлэхэд хийгдсэн ажлууд

Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Орчны бохирдол үүсгэх	Ажилчдын тосгоноос гарах ахуйн бохир усыг цэвэршүүлэх төхөөрөмжийг суурилуулсан.
Усны нөөцийн ашиглалт	Тайлант онд нөхөн сэргээлтийн усалгаанд 1002.5 м.куб ус ашиглах дүгнэлт гарсан хэдий ч өмнөх жилүүдэд үүссэн хиймэл нуурнаас нөхөн сэргээлтийн усыг дахин ашигласан.
Ус ашиглах дүгнэлт гаргуулах	Ус ашиглах дүгнэлт Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар 2023.02.13 /дүгнэлт хавсаргав/
Туул голын сав газраас ус ашиглах зөвшөөрөл авах	Усны газрын дүгнэлтэд үндэслэн Туул голын сав газрын захиргааны даргын 2023.03.02 өдрийн А/08 тоот тушаалаар уг газартай ус ашиглах гэрээ байгуулан ажиллаж байна /дүгнэлт хавсаргав/
Ус бохирдуулсны дүгнэлт авах	Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас 2023.03.27 06/309 тоотгоор гаргасан



	хаягдал усны дүгнэлт, 32 тоот хаягдал ус хаях зайлуулах зөвшөөрөлд үндэслэн, Туул голын сав газрын захиргаатай 21/37 тоот гэрээ байгуулан ажиллаж байна /дүгнэлт хавсаргав/
Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлөх	Ус ашигласны төлбөрийг гэрээнд заасан цаг тухай бүр шилжүүлсэн.
Ус хангамжийн хоолой, усны тоолуурын бүрэн бүтэн байдалд хяналт тавих	Усны тоолуур, заалт, усны шугам хоолойн хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажилласан.

5.3.Хөрсний бохирдол, элэгдэл, эвдрэл

Нөлөөлөл – Хөрс (Хөрс хуулалт, тээвэрлэлт, элс, хөрсний овоолго, баяжуулалт, шатахууны хадгалалт, уурхайн суурин, байгууламж)

Нөлөөлөлд өртөх объект – Малын бэлчээр, шимт хөрс бүхий газар, амьтан, мал, ургамал, уурхайн кемп шатахуун түгээх станцийн ойр орчим

Хүснэгт 6. Хөрсний бохирдолтоос сэргийлэхэд хийгдсэн ажлууд

Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Шимт хөрс хуулах, хадгалах стандартын дагуу 30-50 см орчим хуулж буцаан нөхөн сэргээлтэнд ашиглах, ашиглахгүй тохиолдолд шимт хөрсний овоолгод хадгална.	Энэ жилийн хуулсан шимт хөрсийг бордож буцаан биологийн нөхөн сэргээлтэнд бэлдсэн техник нөхөн сэргээлтийн талбайд тараан байршуулсан.
Техникийн хаягдал тосыг хязгаарлах	Машин техникийн засвар үйлчилгээнээс гарах хаягдал тосыг журмын дагуу цуглуулах, хадгалах, тээвэрлэн үүсгэгчээс боловсруулагчид шилжүүлэн ажилласан /гэрээ хавсаргав/
Хөрсөнд бохирдол үүсэхээс сэргийлэх хог хаягдлыг ангилан ялгах, хогийн цэгт хүргэх, ариутгал халдваргүйтэл хийх	Ажилчдын тосгонд хогийн сав хангалттай байршуулж хог хаягдлыг хогийн саванд ангилан ялгалт хийж хэвшүүлэн, кемпээс гарах хог хаягдлыг цуглуулан хогийн цэгт хүргэж байна.

Машин техникийн засвар үйлчилгээнээс гарах хаягдал тосыг цуглуулан тос устгах “Алтан оршихуй групп” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Хаягдал тос асгарах алдагдахаас сэргийлж алдаа дутагдлыг илрүүлж байнга хяналт тавьж ажилладаг. Уурхайн кемпийн талбайд хаягдал тос цуглуулах талбай 1, уурхайн талбайн үйл ажиллагаа дээр ажиллах хаягдал тос цуглуулах машин тус тус ажиллаж байна (Зураг 6,7).



Зураг 6. Хаягдал тос масло цуглуулах, хадгалах талбай



Зураг 7. Уурхайн талбайн машинистийн хаягдал тос цуглуулах машин

Шимт хөрс хуулалт, тээвэрлэлтийг Монгол улсын стандарт MNS 5916: 2008 стандартын дагуу хадгалж байна. Уурхайн олборлолтын үйл ажиллагаа нөхөн сэргээлтийн үйл ажиллагаатай зэрэгцэн явдаг учир ихэнхдээ шимт хөрсийг шууд нөхөн сэргээлтэнд ашигладаг. Техник нөхөн сэргээлтийн талбайд шимт хөрсийг тараан байршуулахдаа бордоотой хольж нэг жил өнжөөх нь биологийн нөхөн сэргээлтэнд илүү үр дүнтэй байна (Зураг 8,9).



Зураг 8. Шимт хөрс тээвэрлэх үйл явц



Зураг 9. Шимт хөрс хуулах үйл явц

Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж машин техникийн засвар, үйлчилгээ хийхдээ тос түлшний тосгуур тогтмол хэрэглэж байна. Хаягдал тос цуглуулах цэгийн талбайг цементжүүлэн хөрсөнд тос асгарч бохирдохоос сэргийлсэн (Зураг 10, 11).



Зураг 10. Засвар үйлчилгээний цементилсэн талбай



Зураг 11. Хаягдал тос тосох, тусгай талбайн хэсэг

Хөрсний бохирдлоос сэргийлж ажилчдын тосгонд хог хаягдлыг журамлах үүднээс хогын савыг хангалттай байршуулж хог хаягдлыг цуглуулах нэгж ажилтан техник хэрэгсэлтэйгээр ажилласан.

Сум орон нутагтай хог хаягдлын тухай хууль журмын дагуу гэрээ байгуулан ажиллаж байна.



Зураг 12. Ахуйн хог хаягдал зөөх, ачих машин



Зураг 13. Ахуйн хог хаягдлын хогийн сав

Уурхайн олборлолтын ажлын үед зам, талбайн усалгааг шороо босгохгүй байхаар 18м³ багтаамжтай усалгааны зориулалтаар тоногдсон хово маркийн 3 ширхэг автомашинаар тогтмол усалгааны ажил хийж байна.



Зураг 14. Усалгааны машин зам талбай усалж буй байдал

Тоосжилтыг бууруулах үүднээс уурхайн бүсд бүх техник хэрэгслийг нэгдсэн нэг замаар явуулж хурдны хязгаарыг 20-30 км/цаг, ажилчдын тосгонд 5км/цагаар тогтоосон.



Зураг 15. Хурд хязгаарлах замын тэмдэг, тэмдэглэгээ



5.4. Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй

Уулс Заамар ХХК нь нийт ажилчидынхаа эрүүл мэндийн асуудлыг нэгт тавин ажилладаг. Ажилд шинээр орж буй ажилтан тэдгээрийн төрөлхийн болон үүсмэл өвчин тухайн ажлын нөхцөлтэй харшилж буй эсэхэд эмнэлгийн эрүүл мэндийн үзлэгт хамруулан тухайн эмнэлэгийн эцсийн хариу дүгнэлтээс шалгааж ажилтанг эрүүл мэндийн хувьд уг ажилд тохирох хүн эсэхэд сонгон эцсийн хариу шийдвэрийг гаргадаг. Тухайн ажилтанг үйлдвэрийн гарч болзошгүй осол эндэгдлээс урьдчилан сэргийлэх анхны алхам болж өгдөг. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 14-р зүйлд заасны дагуу шинээр ажилд орж байгаа ажилтны мэндийн үзлэгт хамруулж тухайн ажлын байрны нөхцөлд тэнцэж байгаа эсэх талаар хяналт тавьж ажиллаж байна.



Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, төгрөг	Гүйцэтгэл	Нийт зардал, төгрөг
1		2	3	4	5
1	Агаарын чанар	Техникийн хорт хий ялгарах Уурхайн үйл ажиллагаанд оролцож буй бүх техник хэрэгслүүдэд чанарын шаардлага хангасан түлш хэрэглүүлэх, машин техникийн засвар үйлчилгээг төлөвлөсөн хугацаанд тогтмол хийх	-	Тухайн онд уурхайд ажиллах техник, тоног төхөөрөмжүүдэд чанарын шаардлага хангасан түлш хэрэглэсэн.	-
			-	Уурхайн засварын хэсэг нь уурхай дээр ажиллаж буй бүхий л техник тоног төхөөрөмжийг хариуцан бүрэн бүтэн байдлыг байнга хянан засвар үйлчилгээний ажлыг тогтмол хийж байна.	-
		Орчны тоосжилт үүсэх Уурхайн талбайд хуурайшилт, тоосжилт ихтэй үед уурхайн гол зам, талбайг услах	-	Уурхайн олборлолтын ажлын үед зам, талбайн усалгааг шороо босгохгүй байхаар 18 м.куб багтаамжтай усалгааны зориулалтаар тоногдсон хово маркийн 1 ширхэг автомашинаар тогтмол усалгааны ажил хийж байна.	-
			-	Тоосжилтыг бууруулах үүднээс уурхайн бүсэд бүх техник хэрэгслийг нэгдсэн нэг замаар явуулж хурдны хязгаарыг 20-30 км/цаг, ажилчдын тосгонд 5км/цагаар тогтоосон.	-
		Уурхайн үйл ажиллагаанд оролцож буй бүх тээврийн хэрэгслийн агаарт гаргах хаягдалд ноогдуулах төлбөрийг төлөх	-	“Уулс заамар” ХХК нь Төв аймгийн Заамар сумын татварын хэлтэст тушаасан .	481,750.00
	Уурхайд ашиглаж буй нийт техник, тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоог хийлгэх	-	Урд дэлэнгийн дэнж уурхайд ашиглагдаж байгаа бүх тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэгийг Төв аймгийн Авто тээврийн газраас очиж хийсэн. Үзлэгээр тээврийн хэрэгсэлүүд шаардлага хангасан техникийн дүгнэлт гарсан нь техник хэрэгслийн ялгаруулах утаа хүлцэх хэмжээнд байна.	-	



		Уурхай орчмын агаарын бохирдлын дээж авч шинжлүүлж, дүгнэлт гаргуулж холбогдох арга хэмжээ авч байх	270,000	Агаарын орчны хяналт шинжилгээг хийлгэсэн.	500,000.00
2	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Орчны бохирдол үүсгэх	-	Ажилчдын тосгоноос гарах ахуйн бохир усыг цэвэршүүлэх төхөөрөмжийг суурилуулсан.	-
		Усны нөөцийн ашиглалт	-	Тайлант онд нөхөн сэргээлтийн усалгаанд 1002.5 м.куб ус ашиглах дүгнэлт гарсан хэдий ч өмнөх жилүүдэд үүссэн хиймэл нуурнаас нөхөн сэргээлтийн усыг дахин ашигласан	-
		Ус ашиглах дүгнэлт гаргуулах	-	Ус ашиглах дүгнэлт Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар 2023.02.13 /дүгнэлт хавсаргав/	-
		Ус ашиглалтын гэрээг Туул голын сав газрын захиргаатай хийж баталгаажуулах	-	Туул голын сав газрын захиргаатай 2023 оны 3-р сарын 02-ний өдөр А/08 тоот Ус ашиглалтын гэрээг байгуулсан	-
		Ус ашиглалтын төлбөрийг төсвийн дансанд оруулах	-	Туул голын сав газрын захиргаатай 2023 оны 3-р сарын 2-ний өдөр А/08 тоот Ус ашиглах гэрээний 2,10 дагуу.	49,752,075.00
		Ус бохирдуулсны дүгнэлт авах	-	Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас 2023.03.27 06/309 тоотоор гаргасан хаягдал усны дүгнэлт, 32 тоот хаягдал ус хаях зайлуулах зөвшөөрөлд үндэслэн, Туул голын сав газрын захиргаатай 32 тоот гэрээ байгуулан ажиллаж байна /дүгнэлт хавсаргав/	-
		Ус ашиглалтын тайлан бүртгэлийг Туул голын сав газрын захиргаанд тайлагнаж байх	-	Ус ашиглалтын тайлан бүртгэлийг 12-р сарын 20-ны өдрийн дотор холбогдох байгууллагад тайлагнана.	-
Уурхайн үндсэн талбайг үерийн уснаас сайтар хамгаалж суваг шуудуу татах, далан хаалт байгуулах	-	Уурхайн үндсэн талбайг үерийн уснаас сайтар хамгаалж суваг шуудуу татах, далан хаалт байгуулсан.	-		



	Бохир усны сангийн даланг өндөрлөх зэргээр бохир ус халихаас сэргийлж байх	-	Бохир усны сангийн ус халихаас сэргийлж даланг өндөрлөсөн.	-
	Бохир усны санд тор тавьж загас байгаа эсэхийг шалгаж байх	-	Бохир усны санд тор тавьж загас байгаа эсэхийг тогтмол шалгаж байсан.	-
	Ус хангамжийн хоолой, усны тоолуурын бүрэн бүтэн байдалд хяналт тавих	-	Усны тоолуур, заалт, усны шугам хоолойн хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажилласан.	-
	Усны шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулж байх	270,000	Инженер геодези ХХК, Хан лаб ХХК-иудаар шинжилгээ хийлгэсэн.	2,465,000.00
			Ус ашиглуулах дүгнэлтийг 2023 оны 2-р сарын 13-ний өдөр Усны газраар гаргуулсан.	845,000.00
	Шимт хөрс хуулах, хадгалах стандартын дагуу 30-50 см орчим хуулж буцаан нөхөн сэргээлтэнд ашиглах, ашиглахгүй тохиолдолд шимт хөрсний овоолгод хадгална.	-	Энэ жилийн хуулсан шимт хөрсийг бордож буцаан биологийн нөхөн сэргээлтэнд бэлдсэн техник нөхөн сэргээлтийн талбайд 5-н сараас эхлэн тараан байршуулсан.	-
	Техникийн хаягдал тосыг хязгаарлах	-	Машин техникийн засвар үйлчилгээнээс гарах хаягдал тосыг журмын дагуу цуглуулах, хадгалах, тээвэрлэн үүсгэгчээс боловсруулагчид шилжүүлэн ажилласан./	-
3	Хөрсөн бүрхэвч			
	Хөрсөнд бохирдол үүсэхээс сэргийлэх хог хаягдлыг ангилан ялгах, хогийн цэгт хүргэх, ариутгал халдваргүйтэл хийх	-	Ажилчдын тосгонд хогийн сав хангалттай байршуулж хог хаягдлыг хогийн саванд ангилан ялгалт хийж хэвшүүлэн, кемпээс гарах хог хаягдлыг цуглуулан хогийн цэгт хүргэж байна.	-
	Дотоод овоолгын тэгшилгээ	-	Дотоод овоолгоор дүүргэгдсэн хөрсийг түрж хэлбэржүүлэн тэгшилсэн	-
	Хөрсний шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулж ажиллах	180,000	Инженер геодези ХХК, Хан лаб ХХК-иудаар шинжилгээ хийлгэсэн.	273,890.00
4	Газрын хэвлий			
	Алт олборлолтын хаягдал, бохирдолтыг багасгах арга хэмжээ авч байх	-	Алт олборлолтын хаягдал, бохирдолтыг багасгахын тулд угаах төхөөрөмжинд технологийн шинэчлэлтийг хийж ажилласан.	-
	Ашигт малтмал ашигласны төлбөрийг барагдуулах	-	Ашигт малтмал ашигласны төлбөрийг барагдуулсан	-
	Хяналтын сорьцлолтыг өөрсдөө болон мэргэжсэн	-	Хяналтын сорьцлолтыг Сорьцын албаар	-



	байгууллагуудаар нарийвчлан хийлгэж үнэлгээ дүгнэлт гаргуулж байх		нарийвчлан хийлгэсэн.		
	Техник технологийн учир шалтгаанаар гарч буй бодит хаягдлыг багасгах арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэх	-	Техник технологийн учир шалтгаанаар гарч буй бодит хаягдлыг багасгах арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.	-	
	Хөрс хуулалтын явцад элсийг хөрстэй хамт ухаж хаягдал үрэгдэхээс сэргийлэн хяналт явуулах	-	Хөрс хуулалтын явцад элсийг хөрстэй хамт ухаж хаягдал үүсэхээс сэргийлж тогтмол элсний давхаргаас дээш хамгаалалтын давхаргыг үлдээж хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэж байсан.	-	
	Орчинд халгүй шинэ технологийн талаар байнгын судалгаа хийж нэтрүүлэх арга хэмжээний зардлыг уурхайн төсөвт тусгаж хэрэгжүүлэх	-	Орчинд халгүй шинэ технологийн талаар судалгааг хийж байгаа.	-	
5	Ургамлан нөмрөг	Ургамал устгах, талхлагдахаас сэргийлэх арга хэмжээ авч байх	-	Ашиглалтын талбайд олон салаа зам гарахаас урьдчилан сэргийлж тэмдэг тэмдэглэгээ байршуулсан	-
6	Амьтны аймаг	Уурхайн ухаш, нүх, суваг шуудуунд мал, амьтан унаж осолдохоос сэргийлсэн хаалт хашилт хийх	-	Уурхайн ухаш, нүх, суваг шуудуунд далан байгуулсан	-
	Нийт		720,000		54,317,715.00



6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Уулс заамар” ХХК-ий ашиглалтын тусгай зөвшөөрлийн MV-016718 тоот Урд дэлэнгийн дэнж алтны шороон ордын талбайн хэмжээ нь 76.04 га бөгөөд үүнээс 2023 онд олборлолтын үйл ажиллагааны улмаас 1246.45 мян.м куб хөрс хуулж, 29.75 мян.м куб элс олборлож 10.26 га талбай эвдрэлд өртөнө. Үүнээс 191.429 мян.м³ талбайн овоолсон хөрсийг түрж хэлбэржүүлэн тэгшилж, 7.78 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хүснэгт 8. 2023 оны техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Хийгдэх ажил	Төлөвлөгөө	Биелэлт
Техникийн нөхөн сэргээлт			
1	Тайлант оны техникийн нөхөн сэргээлт	0.44 га	7.78 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн



6.1. Техникийн нөхөн сэргээлт

“Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS5917:2008” стандартын шаардлагыг баримтлан дотоод овоолгын талбайд хэлбэржүүлэлт хийсэн.

Үржил шимт хөрсийг хуулах ажил:

Тус уурхайн орчмоос үржил шимт хөрсний дундаж зузааныг 0.5-0.7 м байхаар тооцож, экскаватор болон бульдозерыг хослуулан хуулж, техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд конусан овоолго хийсэн. Уул-техникийн нөхөн сэргээлтийг хийж дууссан газар нь өөрөөр хэлбэл биологийн нөхөн сэргээлт хийх хэсэгт тухайн жилийн олборлолтын ажил зогсохоос өмнө шимт хөрсөөр хучсан.



Зураг 16. Шимт хөрс хуулж овоолсон байдал

Уурхайн ашиглагдсан орон зайд хөрсийг овоолох:

Уулын ажлын улмаас эвдрэлд өртөх газрын хэмжээг багасгах зорилгоор ухагдсан орон зайд, хоосон чулуулаг, хөрсний овоолго, тунгаагуурын нуурыг байрлуулж, газрыг аль болох оновчтой ашиглаж ажилласан.

Урд дэлэнгийн дэнж алтны шороон ордын хувьд ашиглалтын явцад хуулсан хөрсөө ашиглагдсан орон зайд шууд овоолж ажилласан бөгөөд техникийн нөхөн сэргээлтийн зардал нь олборлолтын зардалд ордог давуу талтай. Энэ нь олборлолттой зэрэгцүүлэн шууд нөхөн сэргээлт хийх бодит боломжийг бүрдүүлсэн.



Зураг 17. Дотоод овоолго хэлбэржүүлж нөхөн дүүргэлт хийж буй байдал

Хөрсний овоолгыг тэгшлэх:

Хөрсний овоолго нь ашиглагдсан орон зайд хийгдэж байгаа учир зөвхөн оройн хэсгүүдийг тэгшлэх, хэлбэржүүлэх замаар техникийн нөхөн сэргээлтийг хийх бүрэн боломжтой юм. Хөрсний овоолгыг тэгшлэх зардал нь олборлолтын зардалд ордог болохоор тусад нь зардалд тооцдоггүй.



Зураг 18. Хөрсний овоолгийг тараан хэлбэржүүлсэн байдал



Шимт хөрсөөр хучих:

Тэгшилсэн гадаргууг 0.5-0.7 м орчим зузаантай шимт хөрсөөр хучиж өгсөн.



Зураг 19. Шимт хөрсний конусан овоолго тараасан байдал



Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Төлөвлөлтийн тоо хэмжээ	Төлөвлөлтийн нийт зардал, төгрөг	Гүйцэтгэлийн тоо хэмжээ	Гүйцэтгэлийн нийт зардал, төгрөг
	1	2	3	4	6	7	8
1	Техникийн нөхөн сэргээлт /MV-016718/	Өөрийн хүчээр хийх техникийн нөхөн сэргээлтийн ажлын дүн	га	0.44	1,800,000	7.78	1,867,200.00
	Нийт			Тех – 0.44	1,800,000	Тех – 7.78	1,867,200.00



7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уул уурхайн үйл ажиллагааны дараа нөхөн сэргээлтийг маш сайн хийсэн ч нөлөөлөл ямар нэг хэлбэрээр үлддэг. Тэрхүү нөлөөллийг бууруулах олон арга байдгийн нэг нь дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа юм. Тиймээс төслийн нөхөн сэргээлтийн ажлын дараагаар үлдвэр нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авч ажиллалаа.

Уулс Заамар ХХК-ий хувьд 2023 онд MV-016718 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай Урд дэлэнгийн дэнж алтны шороон ордод олборлолтын үйл ажиллагаа явуулахаас гадна MV-004691 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай Урд дэлэн алтны шороон ордод олборлолтын үйл ажиллагаа явуулсан. Урд дэлэнгийн дэнж алтны шороон ордын биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг БОАЖЯ, НҮБХХ-ийн “Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь” төсөл болон Дэ Нэйче Консерванси байгууллагын ажилтнуудын боловсруулсан “Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх гарын авлага”-ын дагуу хийж гүйцэтгэдэг.

2023 оны Байгаль орчин менежментийн төлөвлөгөөний дагуу нийт талбайн хэмжээнд нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн бөгөөд Туул голын урсацыг сэргээх, хөрсний чийгээр баяжуулах зорилгоор мод бургасны суулгац суулгасан. Заамар сумын байгаль орчны байцаагчтай хамтарч мод бургасны суулгац суулгах ажлыг зохион байгуулсан. Бид энэхүү ажлын хүрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнтэй харилцан уялдуулан 1.8 га талбайд 3597 ш мод суулгацыг тарьсан.

7.1 Мод тарих

2023 оны дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний дагуу биологийн нөхөн сэргээлтийн хэрэгцээнд нийт 3597 ширхэг хайлаас 1991, бургас 286, шар хуас 1320 моддыг биологийн нөхөн сэргээлтэнд ашиглан энэ оны төлөвлөгөөны дагуу нөхөн сэргээлтийн талбайд мод тарьсан. Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайд Агро Форест ХХК -наар моддын төлөв байдлыг үнэлүүлж, экологи эдийн засгийн үнэлгээг хийж гүйцэтгэлээ. 2023 оны тариалсан моддын экологи эдийн засгийн үнэлгээг 20,296,870.00 төгрөгөөр үнэлж тооцсон байна.



Зураг 20. Мод суулгац тарьж буй байдал




Зураг 21. Мод суулгаж тарьсан байдал



7.2 Техникийн нөхөн сэргээлт

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ирүүлсэн санал хүсэлтийн дагуу дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн эвдрэлд орсон талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэлээ. Уг газар нь Заамар сумын Өгөөмөр овооны урд хэсэгт орших бичил уурхайн эвдэрсэн 5 га талбайд (1 га талбай нь MV-016718 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаартай Урд дэлэнгийн дэнж талбайн дүйцүүлэн хамгаалах талбайд орно) техникийн нөхөн сэргээлтийг Монгол улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.



Зураг 22. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Өгөөмөр овооны урд хэсэгт техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбай.



Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

№	Төсөл хэрэгжих талбай	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Төлөвлөлтийн тоо хэмжээ	Төлөвлөлтийн нийт зардал, төгрөг	Гүйцэтгэлийн тоо хэмжээ	Гүйцэтгэлийн нийт зардал, төгрөг
	1	2	3	4	6	7	8
1.	Биологийн нөхөн сэргээлт /MV-016718/	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ	ш	500	460,000	3597	6,300,000.00
2.	Техникийн нөхөн сэргээлт /MV-016718/	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	га	1		1	4,400,000.00
	Нийт				460,000		10,700,000.00



8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Манай компани нь Урд дэлэнгийн дэнж алтны шороон ордод 2023 оноос эхлэн олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт MV-016718 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн 76.04 га талбайд өвөлжөө, хаваржаа зэрэг нүүлгэн шилжүүлэх объект байхгүй болно.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Урд дэлэнгийн дэнж алтны шороон ордын MV-016718 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 1998 оноос эхлэн хайгуулын ажил хийгдсэн бөгөөд 2012 онд хийгдсэн хайгуулын ажлаар түүх, соёлын өв тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд байхгүй болох нь тогтоогдсон.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Эрсдлийн үнэлгээнд химийн хорт болон аюултай бодисын хор, аюулын шинж чанар, болзошгүй эрсдлийг судлан тодорхойлох, түүнээс сэргийлэх арга хэмжээ болон хаягдлыг хоргүйжүүлэх, устгах асуудлыг хамруулан хийдэг. “Уулс Заамар” ХХК-ий Төв аймгийн Заамар сумын нутагт хэрэгжих Урд дэлэнгийн дэнж алтны шороон орд төслийн хувьд хүний эрүүл мэнд болон байгаль орчинд шууд нөлөөлөх онцгой химийн хорт бодис болон цацраг идэвхит аюултай бодис ашигладаггүй.

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Заамар-Эх уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа бүх төрлийн хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах зохистой арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.



Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн хураангуй

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн хураангуй	
Төлөвлөгөө	Биелэлт
Энгийн хог хаягдлын гэрээ байгуулах	Энгийн хог хаягдлыг дахин ашиглах зайлуулах ажлыг үргэлжлүүлэн хийж орон нутагтай хууль журмын дагуу гэрээ байгуулан төлбөр тооцоог төлж ажилласан.
Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарсан аюултай хог хаягдлыг зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад шилжүүлэх	Энэ онд үйлдвэрлэлийн үйл ажиллааны улмаас техникийн хаягдал тос, хуванцар сав, аккумулятор, поошиг зэрэг хаягдал гарсан бөгөөд зохих журмын дагуу зайлуулах, цуглуулах, нийлүүлэгчид буцаах зэрэг арга хэмжээ авсан
Ажилчдын хотхоноос гарах хог хаягдлыг ангилан ялгах	Ажилчдын хотхоноос гарах ахуйн хуванцар сав, лаазыг цуглуулж тээвэрлэн сумын түүхий эд авах цэгт хүргэж байна. Цаашид ангилан ялгах нэр төрлийг нэмэгдүүлж ажиллана.
Үйлдвэрлэлээс гарах хог хаягдлыг ангилан ялгах	Үйлдвэрлэлээс гарах энгийн хог хаягдал нь дугуй, төмөр, мод зэрэг бөгөөд дугуйны заримыг нь нутгийн иргэдэд өгдөг, төмөр болон модыг дахин ашиглах боломжтойг нь ашиглаж үлдсэнг нь тусгай талбайд хурааж байна.
Аюултай хог хаягдлыг устгах зайлуулах гэрээ байгуулах, үүсгэгчийн дугаар авах	Туслан гүйцэтгэх “Рекламешн сервис” ХХК нөхөн сэргээлтийн компани дээр ашиглах бордооны сав баглаа боодол дээр аюултай хог хаягдал үүсгэгчийн дугаар авч журмын дагуу хадгалж, гэрээт байгууллагад хүргэж ажиллаж байна.

Тайлант онд хийсэн голлох ажил нь ажилчдын ахуйн хэрэгцээнээс гарч буй хуванцар хаягдлыг ангилан ялгаж цуглуулан түүхий эд авах цэгт тушаадаг болсон. Мөн техникийн хаягдал тосыг цуглуулан “Алтан оршихуй групп” ХХК-тай гэрээний дагуу хүргэж өгсөн.

Уурхайн тосгоны хэмжээнд хоногт дунджаар 50 кг орчим хатуу хог хаягдал бөөгнөрдөг. Эдгээр хатуу хог хаягдалыг тусгай газарт бөөгнөрүүлэн Төв аймгийн Заамар сумын ЗДТГ-тай 2023.05.22 өдөр Монгол улсын Хог хаягдлын тухай хуулийн дагуу гэрээ байгуулан ажилласан.



Зураг 23. Хатуу хог хаягдал зөөвөрлөх машин



Зураг 24. Хатуу хог хаягдал цуглуулах талбай

Ажилчдын тосгоны дунд хог хаягдлын ангилан ялгалтаар үүссэн дахивар хог хаягдлыг цуглуулж, боловсруулах үйлдвэр, дахин ашиглах газруудад нийлүүлэх ажлыг зохион байгуулж байна. Дахин ашиглах хог хаягдлыг цуглуулах хогийн сав байршуулан ус, ундааны хуванцар сав болон шил, лаазыг цуглуулж түр хадгалах, цуглуулах талбайд хураан Заамар сумын Шижир алт багын түүхий эд авах цэгт тушааж байна. Энэ онд 50 кг орчим хуванцар сав лаазыг цуглуулж тушаагаад байна.



Зураг 25. Хуванцар сав, шил лааз цуглуулах хогийн цэг



Зураг 26. Хуванцар сав, шил лааз цуглуулах хадгалах талбай

Аюултай хог хаягдал болох хөрс бордооны сав баглаа, боодол болон ашиглагдсан техникийн батарей, аккумулятор зэргийг холбогдох журмын дагуу “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх,



тайлагнах журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж зориулалтын агуулахад хурааж хадгалан гэрээт байгууллагад тушааж байна.



Зураг 27. Хөрс бордооны сав, баглаа боодлыг хадгалах агуулах



Зураг 28. Техникийн ашиглагдсан батарей, аккумулятор хадгалах агуулах



Хүснэгт 12. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, төгрөг	Гүйцэтгэл	Нийт зардал, төгрөг
1	2	3	4	5	
1	Ахуйн	Ахуйн шингэн хог хаягдлыг бохирын цэгт хадгалж халдваргүйжүүлэх	180,000	Заамар сумтай гэрээ байгуулсан	250,000.00
		Ажиллагсдын халуун усны газар болон бие засах газрыг ариутгаж халдваргүйжүүлэх	-	Ажиллагсдын халуун усны газар болон бие засах газрыг ариутгаж халдваргүйжүүлсэн	-
2	Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн шингэн хог хаягдлыг тунаах нуураар дамжуулан эргүүлэн ашиглах	-	Үйлдвэрлэлийн шингэн хог хаягдлыг тунаах нуураар дамжуулан эргүүлэн ашигласан	-
		Үйлдвэрлэлийн хатуу хог хаягдлыг ялгаж устгах	-	Үйлдвэрлэлийн хатуу хог хаягдлыг ялгаж устгасан	-
3	Бусад	Дахин боловсруулагдах хог хаягдлыг Улаанбаатар хот руу тээвэрлэх	-	Дахин боловсруулагдах хог хаягдлыг Улаанбаатар хот руу тээвэрлэсэн	-
		Дахин болосруулагдахгүй хог хаягдлыг багийн хог хаягдлын цэг рүү тээвэрлэх	180,000	Заамар сумтай гэрээ байгуулсан	425,000.00
Нийт			360,000		675,000.00



12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Урд дэлэнгийн дэнж уурхайд 2023 онд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөгөөний дагуу дараах байдлаар шинжилгээ хийлгэсэн. Хуулбарыг хавсаргав.

1. Усны орчинд тунгаагуур нуур, ундны худагнуудаас БОАЖЯ Усны газар Хяналтын Төв Лаборатор, Хан Лаб ХХК, Инженер геодези ХХК-аар MNS 4943:2015 стандартын Алтны шороон ордод шаардлагатай үзүүлэлтүүдээр шинжлүүлсэн бөгөөд зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үзүүлэлт гараагүй байна.
2. Хөрсний орчинд шимт хөрсний овоолго, нөхөн сэргээлтийн талбай, хөрс хуулалтын бүсээс дээж авч Хан Лаб ХХК, Инженер Геодези ХХК-иар шинжлүүлсэн.
3. Агаарын орчинд бид ажилчдын хотхон, олборлолтын талбай, талбайн технологийн зам дагуу зэрэг газар агаарт Цаг уур, орчны шинжилгээний газар, байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторитой хамтран баталгаат багажаар дуу чимээ /ДБА/, агаарын нарийн ширхэглэгт тоосонцор /PM2.5/, том ширхэглэгт тоосонцор /PM10/, Азотын давхар исэл /NO₂/, хүчиллэг хий /SO/ зэргийг хэмжих суурин боловсруулалтын хүрээнд хэмжиж авсан. Агаар дахь тоосонцор , хүхэрлэг хий, азотын давхар ислийг хэмжсэн. Хэмжилтйн үр дүнг “Агаарын техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 стандарттай харьцуулав.Стандартаас давсан үзүүлэлт гараагүй

Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээ

№	Орчны хяналт шинжилгээ	Зардал, төгрөг	Гүйцэтгэл	Зардал, төгрөг
1	Усан орчны хяналт шинжилгээ	270,000	Усан орчны хяналт шинжилгээг хийлгэсэн	2,465,000.00
2	Хөрсөн орчны хяналт шинжилгээ	180,000	Хөрсөн орчны хяналт шинжилгээг хийлгэсэн	273,890.00
3	Агаарын орчны хяналт шинжилгээ	270,000	Агаарын орчны хяналт шинжилгээг хийлгэсэн	500,000.00
4.	Ажлын байрны орчин нөхцөл	100.000	Ажлын байрны орчин нөхцөл хийлгэсэн	
	Нийт	820,000		3,238,890.00



Хүснэгт 14. Усны шинжилгээний хариу

2023.05.31				
№	Үзүүлэлт (мг/л)	Шинжлэх аргын стандарт	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Үр дүн
1	pH-Усны орчин	MNS ISO 10523-2001	6.09-9.0	7.23
2	NH ⁴⁺ Аммони	MNS ISO 4428:1997	-	0.59
3	CL ⁻ Хлорид	MNS ISO 9297:2007	-	81.53
4	(SO ₄) ²⁻ Сульфат	MNS ISO 6271:2011	-	143.94
5	Умбуур бодис	MNS ISO 11923:2001	<30.0	48.00
6	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч /COD/	ХТЛ-СА3-4/02	<50.0	100.60
7	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч /BOD/	ХТЛ-СА3-4/01	<20.0	38.69
8	(NO ₂) Нитрит	MNS ISO	-	0.00
9	(NO ₃) Нитрат	MNS ISO	-	0.06
2023.08.16				
№	Үзүүлэлт (мг/л)	Шинжлэх аргын стандарт	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Үр дүн
1	pH-Усны орчин	MNS ISO 10523-2001	6.09-9.0	8.70
2	NH ⁴⁺ Аммони	MNS ISO 4428:1997	-	0.74
3	CL ⁻ Хлорид	MNS ISO 9297:2007	-	67.35
4	(SO ₄) ²⁻ Сульфат	MNS ISO 6271:2011	-	120.33
5	Умбуур бодис	MNS ISO 11923:2001	<30.0	8.00
6	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч /COD/	ХТЛ-СА3-4/02	<50.0	44.20
7	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч /BOD/	ХТЛ-СА3-4/01	<20.0	17.00
8	(NO ₂) Нитрит	MNS ISO	-	0.00
9	(NO ₃) Нитрат	MNS ISO	-	0.55



2023.09.09							
Усны химийн задлан шинжилгээний дүн							
Анион	Мг/л	Мг/экв	%, Мг-экв/л	Катион	Мг/л	Мг/экв	%, Мг-экв/л
Cl	21.98	0.62	16.34	NA+K	38.32	1.67	43.98
SO ₄	30.50	0.64	16.76	NH ₄	0.40	0.02	0.59
NO ₃	2.06	0.03	0.88	Ca ²⁺	24.02	1.20	31.67
NO ²	0.05	0.00	0.03	Mg ²⁺	10.94	0.90	23.76
CO ₃	6.00	0.10	2.64	Fe ²⁺	0.00	0.00	0.00
HCO ₃	146.45	2.40	63.35	Fe ³⁺	0.00	0.00	0.00
Дүн	207.04	3.79	100.00	Дүн	73.72	3.79	100.00
Анион, катионуудын нийлбэр					Мг/л	280.76	
HCO ₃ -ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр					Мг/л	208.0	
Хуурай үлдэгдэл					Мг/л	258.0	
Ерөнхий хатуулаг					Мг-экв/л	2.10	
pH					8.69		
Исэлдэх чанар					Мг/л	3.36	
Усны физик шинж чанар							
Шүүгдэсний өнгө					шаравтар		
Үнэр					Үгүй		
Амт					-		
Булингар					Тунгалаг		
Тунадас					үгүй		

Тунаах нуурын усыг “Ханлаб”-ын лабораторид өгч MNS 4943:2015 стандартын Алтны шороон ордод шаардлагатай үзүүлэлтүүдээр шинжлүүлсэн бөгөөд зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үзүүлэлт гараагүй байна.

Тунаах нуурын усны 9-р сарын шинжилгээ “Инженер геодези” лабораторын хариу (MNS 1097:1970, MNS 6271:2011, MNS ISO 10523:2001, MNS ISO 9297:2005, MNS ISO 6059:2005) стандартаар шинжлэв. Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хуьд цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, зөөлөн ус байна.



Хүснэгт 15. Хөрсний шинжилгээний хариу / Шинжилгээ хийсэн арга стандарт MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020/

Үзүүлэлт		2023.05.03		2023.08.21		2023.09.09	
		Шимт хөрс	Дотоод овоолго	Шимт хөрс	Дотоод овоолго	Шимт хөрс	Дотоод овоолго
pH		8.47	9.50	8.96	-	9.11	9.54
Давс		0.19	0.10	-	-	0.54	0.07
ЦДЧ		0.399	0.209	-	-	1.112	0.137
Ялзмаг		2.10	0.05	0.466	-	1.12	0.44
CaCO ₂		0.00	2.88	9.27	-	2.80	1.15
Шингээгдсэн сууриуд мг-экв/100гр	Ca	13.1	4.7	-	-	10.4	10.3
	Mg	6.2	3.3	-	-	7.0	7.4
Шим тэжээлийн элементүүд мг/100гр	P ₂ O ₅	3.3	0.8	0.51	-	2.4	2.4
	K ₂ O	22	33	7.9	-	11	17
Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм	1-0.25	17.2	28.6	-	-	13.1	55.6
	0.25-0.05	52.0	34.6	-	-	44.6	19.5
	0.05-0.01	14.9	12.2	-	-	11.8	7.5
	0.01-0.005	4.5	4.9	-	-	5.8	2.1
	0.005-0.001	5.9	12.9	-	-	16.5	10.3
	<0.001	5.5	6.7	-	-	8.2	5.0
	<0.01	15.9	24.6	-	-	30.5	17.4

Хүснэгт 16. Уурхайн агаарын шинжилгээний хариу

2023.05.15							
№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Том ширхэглэгт тоосонцор /PM 10/ мкг/м ³	Нарийн ширхэглэгт тоосонцор /PM2.5/ мкг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Олборлолтын талбай /цэг 2/	05.15	0.020	0.021	60	15	45
2	Талбайн технологийн зам дагуу /цэг 2/	05.15	0.019	0.027	60	15	50
3	Ажилчдын тосгон	05.15	0.021	0.018	30	45	35
MNS 4585:2016			0.45	0.200	100	50	60



2023.08.09							
№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Том ширхэглэгт тоосонцор /PM 10/ мкг/м ³	Нарийн ширхэглэгт тоосонцор /PM2.5/ мкг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Олборлолтын талбай /цэг 2/	08.09	0.019	0.020	57	10	45
2	Талбайн технологийн зам дагуу /цэг 2/	08.09	0.018	0.025	57	10	50
3	Ажилчдын тосгон	08.09	0.020	0.017	20	50	30
MNS 4585:2016			0.45	0.200	100	50	60
2023.09.30							
№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Том ширхэглэгт тоосонцор /PM 10/ мкг/м ³	Нарийн ширхэглэгт тоосонцор /PM2.5/ мкг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Олборлолтын талбай /цэг 2/	09.30	0.020	0.022	58	12	40
2	Талбайн технологийн зам дагуу /цэг 2/	09.30	0.018	0.027	57	12	50
3	Ажилчдын тосгон	09.30	0.020	0.019	22	50	30
MNS 4585:2016			0.45	0.200	100	50	60

Агаар дахь тоосонцор , хүхэрлэг хий, азотын давхар ислийг хэмжсэн. Хэмжилтйн үр дүнг “Агаарын техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 стандарттай харьцуулав. Стандартаас давсан үзүүлэлт гараагүй. 3 цэгт хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосонцорын агууламж, дуу чимээг хэмжиж үзэхэд стандарт үзүүлэлтээс давсан үзүүлэлт байхгүй байна.



Байгаль орчин аялал жуучлал яам, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа хамтын ажиллагааны төвд шинжлүүлсэн хөрс, усан орчны хяналт шинжилгээний хариу.

Цэвэр усны химийн шинжилгээ Гүний худаг:				2023.07.03-07.28
№	Үзүүлэлт (мг/л)	Шинжлэх аргын стандарт	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Үр дүн
1	pH-Усны орчин	MNS ISO 10523-2001	6.5-8,5	7.87
2	Цахилгаан дамжуулах чанар	MNS ISO 7888:1999	<1.0	1.12
3	Карбонат, (CO ³⁻)	MNS ISO 9963-1:2005	-	0.00
4	Гидрокарбонат, (HCO ₃)	MNS ISO 9963-1:2005	-	341.60
5	Ерөнхий хатуулаг	MNS ISO 6059:2005	<7.0	7.60
6	Кальци	MNS 1097:1970	<100.0	68.14
7	Магни	MNS 1097:1970	<30.0	51.07
8	CL ⁻ Хлорид	MNS ISO 9297:2007	<350.0	116.99
9	Хуурай үлдэгдэл	MNS 4426:1997	<1000.0	823.0
10	Сульфат (SO ₄) ²⁻	MNS ISO 6271:2011	<500.0	160.88
11	Нитрат (NO ₃ ⁻)	MNS ISO 7890-3:2001	<50.0	4.48
12	Нитрит (NO ₂ ⁻)	MNS 4431-2005	<1.0	0.01
13	Аммони (NH ₄ ⁺)	MNS 1097:1970	<1.5	0.07
14	Төмөр (Fe ³⁺)	MNS 4430:2005	<0.3	0.00
15	Натри+Кали, (NA ⁺ ,K ⁺)	MNS 1097:1970	<200	213.50



Тунгаах нуур		2023.07.03-07.28		
№	Үзүүлэлт (мг/л)	Шинжлэх аргын стандарт	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Үр дүн
1	pH-Усны орчин	MNS ISO 10523-2001	6.09-9.0	8.16
2	NH ⁴⁺ Аммони	MNS ISO 4428:1997	-	3.22
3	CL ⁻ Хлорид	MNS ISO 9297:2007	-	70.90
4	(SO ₄) ²⁻ Сульфат	MNS ISO 6271:2011	-	104.21
5	Умбуур бодис	MNS ISO 11923:2001	<30.0	18.0
6	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч /COD/	ХТЛ-СА3-4/02	<50.0	30.80
7	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч /BOD/	ХТЛ-СА3-4/01	<20.0	11.84
8	(NO ₂) Нитрит	MNS ISO	-	0.02
9	(NO ₃) Нитрат	MNS ISO	-	0.92
10	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч 1 мт-т	MNS 5668:2006	илрэхгүй	илрээгүй



Үзүүлэлт		2023.08.13-08.18		
		Шимт хөрс	Дотоод овоолго	Карьер
рН		9.04	9.15	8.68
Давс		0.20	0.08	0.18
ЦДЧ		0.009	0.017	0.010
Ялзмаг		0.56	0.32	0.26
СаСО ₃		8.12	6.60	1.13
Шингээгдсэн сууриуд мг-экв/100гр	Са ²⁺	10.63	10.00	10.00
	Мg ²⁺	6.25	1.80	1.80
Шим тэжээлийн элементүүд мг/100гр	К ₂ О	5.54	14.24	9.04
	Р ₂ О ₅	0.71	1.00	0.56
Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм	1-0.25	19.31	51.47	60.01
	0.25-0.05	44.84	24.16	21.92
	0.05-0.01	14.68	9.28	3.56
	0.01-0.005	10.40	4.32	2.20
	0.005-0.001	3.52	6.64	5.84
	<0.001	7.25	4.13	6.47
	<0.01	21.17	15.09	14.51



13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 17. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Нийт зардал, төгрөг	Хэрэгжилт	Нийт зардал, төгрөг
1	Байгаль орчны асуудлыг нэг мэргэжилтэнд хариуцуулж дотоод хяналтын ажилтан өөрөө хяналт тавин ажиллах		Байгаль орчны асуудлыг нэг мэргэжилтэнд хариуцуулж дотоод хяналтын ажилтан өөрөө хяналт тавин ажилласан	-
2	Жил бүрийн байгаль орчныг менежментийн төлөвлөгөөгөөр гүйцэтгэх ажлыг төлөвлөн боловсруулж БОАЖЯамаар батлуулан ажиллах		2023 оны байгаль орчныг менежментийн төлөвлөгөөгөөр гүйцэтгэх ажлыг төлөвлөн боловсруулж БОАЖЯамаар батлуулан ажилласан	-
3	Төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх ажлыг чанартай хийлгэх		Төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх ажлыг чанартай хийлгэсэн	-
4	Уулын ажлын төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалх талаар тодорхой ажлуудыг тусган түүнийг мөрдөн ажиллах		Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах талаар тодорхой ажлуудыг мөрдөн ажилласан	-
5	Нийт ажиллагсдад байгалийн баялаг ашиглах, байгаль хамгаалах асуудлаар мэргэжлийн байгууллагын хүмүүс, сум, аймгийн байгаль орчны байцаагч нараар яриа хийлгэх	100,000	Нийт ажиллагсдад байгалийн баялаг ашиглах, байгаль хамгаалах асуудлаар мэргэжлийн байгууллагын хүмүүс, сум, аймгийн байгаль орчны байцаагч нараар яриа хийлгэсэн	100,000.00
6	Байгаль орчин, газар ашиглалтын тайлангаа сумын иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хуралд танилцуулж тайлангаа сумын иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хуралд танилцуулж байх	100,000	Байгаль орчин, газар ашиглалтын тайлангаа сумын иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хуралд танилцуулж тайлангаа сумын иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хуралд танилцуулсан	100,000.00
7	Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг орон нутгийн иргэдийн хурал, Байгаль орчин аялал жуулчлалын яаманд танилцуулж байх	100,000	Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг орон нутгийн иргэдэд таниулан ажилласан	100,000.00
	Нийт	300,000		300,000.00



14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 16. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуца н зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар	Хэрэгжилт
1	2	3	4	5	6	7	
1	Заамар сумын иргэд нийтийн тэргүүлэгчдийн хурал	Тайлан	БОМТБиелэлт	1-р улирал	БО-ны ажилтан	Сумын төвд	Танилцуулсан
2	Төв аймгийн БОАЖГазар	Тайлан	БОМТБиелэлт	4-р улирал	БО-ны ажилтан	Төв аймгийн БОАЖГазар	Тайлан хүргүүлсэн
3	БОАЖЯ-нд	Тайлан	БОМТБиелэлт	4-р улирал	БО-ны ажилтан	БОАЖЯ-нд хүргүүлнэ	Тайлан хүргүүлсэн
Нийт							



15. УРД ДЭЛЭНГИЙН ДЭНЖ УУРХАЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НИЙТ ЗАРДАЛ

*Хүснэгт 17. Урд дэлэнгийн дэнж уурхайн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал*

№	Хийгдэх ажил	Зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	51,078,825.00
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1,867,200.00
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	10,700,000.00
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	675,000.00
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,238,890.00
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	300,000.00
7	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
НИЙТ ЗАРДАЛ		67,859,915.00